




## Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл (2-р үе шат)

Мэдээллийн тойм Дугаар 1: Төслийн танилцуулга (2014.02)



Дээд тал: Дөрвөн замын орчмоос Гандантэгчлэн хийд болон Зурагтын антен харагдах чиглэлд утаагүй болон утаатай өдрийн байдал (2010 он)  
Зүүн доод тал: Богдхан уулаас харагдах хотын байдал (2014 оны Цагаан сар, Б Бямбасүрэнгийн авсан зураг)  
Баруун доод тал: Орчны агаар бохирдуулах бодисын агууламжийн хэмжилтийн байдал (2011 он)

### ЖАЙКА (Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага) –ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар

УБ хот Сүхбаатарын талбай-3 Бодь цамхаг 7 давхар  
TEL: +976-11-325939, 312393 FAX: +976-11-310845  
<http://www.jica.go.jp/mongolia/index.html>

### Төслийн ажлын газар

НАЧА (Нийслэлийн Агаарын Чанарын Алба)  
УБ хот Чингэлтэй дүүрэг Жигжиджавын гудамж-9 Хангарьд ордон 4 давхар  
TEL: +976-11-318551 FAX: +976-11-318551  
<http://www.airquality.ub.gov.mn/>

## Өнөөгийн байдал

Улаанбаатар хотын агаарын бохирдол (АБ) нь ялангуяа өвлийн улиралд ноцтой байдалтай болдог бөгөөд агаар бохирдуулах бодисын хувьд тоос, тоосонцор ( $PM_{10}$  болон  $PM_{2.5}$ ) голлох хувийг эзэлдэг. ЦУОШГ (Цаг уур, орчны шинжилгээний газар)-ын мэдээнээс үзэхэд УБ хотын агаар орчны хяналт шинжилгээний суурин харуулын хэмжилтийн дүнд 2011 оны өвөл  $PM_{10}$ -ын сарын хамгийн өндөр дундаж агууламж  $1,000 \text{ мкг/м}^3$  орчимд хэлбэлзэж, нийт суурин харуул дээр МУ-ын байгаль орчны стандарт (24 цагийн дүнгээр  $100 \text{ мкг/м}^3$ , жилийн дундаж дүнгээр  $50 \text{ мкг/м}^3$ )-аас давсан өндөр агууламжтай байгаа нь хотын иргэдийн эрүүл мэндэд муугаар нөлөөлөх түвшинд хүрээд байна. Түүнчлэн бусад агаар бохирдуулах бодис  $SO_2$  болон  $NO_x$ -ын хувьд ч бүтэн жилийн туршид байгаль орчны стандартаас хэтэрсэн тохиолдлууд ажиглагддаг.

Томоохон бохирдуулах эх үүсвэрүүдийн хувьд жилийн нүүрсний зарцуулалт нь 6 мян.тонноос давдаг эрчим хүч, дулаан үйлдвэрлэлийн гурван ЦС (ДЦС II, III, IV), 200 гаруй УХЗ (усан халаалтын зуух)-ны байгууламж, мөн 1000 гаруй нүүрсэн галлагаат нам даралтын халаагч (бага оврын УХЗ), 170 мян. хол давсан гэр хорооллын айл өрхийн олон тооны гэрийн зуух, ханын пийшин зэргүүд багтдаг. Монгол нь нүүрсний арвин нөөцтэй улс бөгөөд эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж нь нүүрсэнд голлон түшиглэдэг. Одоо нийслэлд хэрэглэгдэж буй ихэнх нүүрс нь чийглэг болон үнслэгийн агуулагдах хэмжээ ихтэй учраас шаталтын үед тортог их хэмжээгээр ялгарч байдаг. Мөн олон тооны автомашинаас ялгарах хаягдал утаа болон автозамын тоос шороо, ДЦС-ын үнсэн сангаас хийсэх үнс зэрэг нь агаар бохирдуулах бусад эх үүсвэрүүд болж байна. Тус төслийн 1-р үе шатны хэмжилтийн дүнгийн тооцоололд тухайлбал, 2011 оны ялгарлын хэмжээ нь тоос 38,758 тонн,  $PM_{10}$  26,529 тонн байдаг.

Өнөөгийн байдлаар агаарын чанарын байдалд дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээлэл, хэмжилтийн өгөгдлийн итгэлцүүрт байдал хангалтгүй байгаа бөгөөд  $PM_{10}$  болон  $PM_{2.5}$ -ын агаар орчны агууламж, найрлагыг бүрэн тодорхойлох чиглэлээр бусад хандивлагч байгууллагатай хамтран ажиллаж байгаа хэдий ч хараахан сайн дүн шинжилгээ хийж чадахгүй байна. Ялангуяа, өвлийн ид хүйтэн үед мониторингийн багаж төхөөрөмжийн ажиллагааны тогтворгүй байдлаас дээрх 2 бодисын орчны агууламжийн итгэлцүүрийн түвшин хангалтгүй байдаг. АБ-ыг үр дүнтэй бууруулах хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд техник, технологийн найдвартай байдал болон шинжлэх ухааны үндэслэл, холбогдох байгууллагуудын ажлын уялдаа холбоо, хууль эрх зүйн орчны боловсронгуй байдал шаардлагатай хэдий ч өнөөгийн боловсон хүчний нөөц, байгууллагын ур чадавхийн хувьд эдгээр нөхцөл, шаардлагыг хангах түвшинд хүрч чадаагүй байна. Иймд боловсон хүчний нөөц, салбарын бүтэц тогтолцоо, төр захиргааны байгууллагын ур чадавхийг сайжруулж, УБ хотын нөхцөл байдалд тохирсон АБ-ыг бууруулах хяналтын тогтолцоог бий болгох нь чухал юм.

Монголын Засгийн газрын хүсэлтээр Японы Засгийн газар эдгээр нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор ЖАЙКА -ын техникийн хамтын ажиллагааны шугамаар “Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг 2010 -2013 оны хооронд хэрэгжүүлсэн ба төслийн хүрээнд бохирдлын эх үүсвэрийг хянах НАЧА болон холбогдох байгууллагын ур чадавхийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа, ялангуяа УХЗ зэрэг бохирдлын эх үүсвэрээс ялгарах тоос,  $PM_{10}$  болон бусад бохирдуулах бодисын агууламжийг тодорхойлох утааны хийн хэмжилт, ялгарлын инвентор, тархалтын загварчлалыг боловсруулах ажил, мөн УХЗ-ны бүртгэл, хяналтын тогтолцооны хүрээнд эх үүсвэрийг журамлах, ялгарлыг бууруулах арга хэмжээний техникийн үнэлгээний ур чадавхийг эзэмшүүлэхэд чухалчлан анхаарсан.

2012 онд Монголын Засгийн газраас энэ салбарын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг хүссэний дагуу Японы Засгийн газар төслийн 2-р үе шатыг 2013 оноос хэрэгжүүлэхээр болсон.

## Эрхэм зорилго, Төслийн Зорилт ба Гарах үр дүн

НАЧА болон салбарын холбогдох байгууллагаас бүрдсэн Х/Т-АХ (Хамтрагч тал-Ажлын хэсэг) нь ЖАЙКА-ын мэргэжилтний багтай төслийн эрхэм зорилго, зорилтыг биелүүлэхэд чиглэсэн 9 үйл ажиллагааны хүрээнд хамтран ажиллана.

### Хүснэгт: Хугацаа, Эрхэм зорилго, Төслийн зорилт болон Гарах үр дүн

Төслийн нэр	Улаанбаатар хотын Агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл (2-р үе шат)
Хугацаа	2013 оны 11сар- 2017 оны 5 сар (3 жил 6 сар)
Эрхэм зорилго	УБ хотын агаар бохирдуулах бодисын ялгарлыг бууруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах
Төслийн зорилт	УБ хот болон бусад холбогдох байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх, бүтэц зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх талыг чухалчлан анхаарч, УБ хотын агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээний хяналтын чадавхийг бэхжүүлэх
Үр дүн 1	Ялгарлын эх үүсвэрийн дүн шинжилгээний чадавхийг сайжруулах
Үр дүн 2	Агаарын чанарын дүн шинжилгээний чадавхийг сайжруулах
Үр дүн 3	Ялгарлын инвентор, тархалтын загварчлал болон агаарын чанарын хяналтын нэгдсэн цогц байдлыг хангаж, бохирдлын эх үүсвэрийн үнэлгээний чадавхийг бэхжүүлэх
Үр дүн 4	НАЧА болон холбогдох байгууллагын шинжлэх ухааны үндэслэлтэй мэргэжлийн судалгаа, дүгнэлтийг ашиглан АБ-ын эсрэг авах арга хэмжээтэй холбоотой шийдвэр гаргах процедурыг сайжруулах.
Үр дүн 5	НАЧА болон холбогдох байгууллагаас ард иргэдэд чиглэсэн агаарын бохирдлын талаарх сургалтыг зохион байгуулж, сэрэмжлүүлэг зарлах системийг нэвтрүүлэх
Үр дүн 6	АБ-ын эсрэг авах арга хэмжээний техникийн үнэлгээний чадавхийг сайжруулах.
Үр дүн 7	НАЧА, холбогдох байгууллагын ялгарлын эх үүсвэрт хэм хэмжээ тогтоож журамлах, хяналт тавих чадавхийг бэхжүүлэх
Үр дүн 8	НАЧА болон холбогдох байгууллагын хяналт, удирдлагын дор гол бохирдуулах бодисын ялгарлын эх үүсвэрийг ашиглагч, үйл ажиллагаа эрхлэгчийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хэрэгжилтийг идэвхжүүлэх.
Үр дүн 9	Үр дүн 1-8-тай холбогдуулсан НАЧА болон холбогдох байгууллагын хамтын ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах.

Төслийн 1-р үе шатнаас гарсан үр дүн, олсон сургамжид тулгуурлан төслийн зорилтыг биелүүлэхийн тулд 2-р үе шатны үйл ажиллагаа нь монголын өнөөгийн бодит байдлыг тусгасан дараах 4 үе шатлалаас бүрэлдэх агаар орчны хяналт, удирдлагын мөчлөг, тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдэнэ. (i) Агаарын чанарын дүн шинжилгээ болон эх үүсвэрийн ба АБ-ыг бууруулах арга хэмжээний үнэлгээ, (ii) АБ-ыг бууруулах стратеги, бодлого болон шийдвэр гаргалт, (iii) АБ-ыг бууруулах арга хэмжээний үнэлгээ, (iv) Арга хэмжээний хэрэгжүүлэлт. Тус мөчлөгийг бүрдүүлэхэд төслөөр дамжуулан НАЧА, ЦУОШГ зэрэг мэргэжлийн байгууллагын техникийн үр чадавхийг ашиглаж ажилласнаар УБ хотын хэмжээнд АБ-ыг бууруулахад төр захиргааны түвшинд зөв зохистой шийдвэр гаргах процедурыг сайжруулах боломжтой юм.

Мөн 1-р үе шатнаас эхлэн хэрэгжиж буй боловсон хүчнийг чадавхижуулах үйл ажиллагааны хүрээнд хамтрагч байгууллага, холбогдох оролцогч талуудтай хамтран ажиллах механизмыг улам бэхжүүлэн ажиллах болно.




⑤ Агаар орчны хяналтын мөчлөг (шат дараалал)-ийн тогтолцоог бүрдүүлэх  
Үйл ажиллагаа 9:

## Төсөл хэрэгжилтийн бүтэц, тогтолцоо

Төсөл хэрэгжилт нь дараах схемд үзүүлсэн байгууллага, мэргэжилтнүүдээс бүрдэнэ. НАЧА нь төслийн гол хэрэгжүүлэгч байгууллага Х/Т (Хамтрагч тал) бөгөөд Х/Т-АХ (Хамтрагч тал-Ажлын хэсэг) нь бусад салбарын холбогдох байгууллагуудаас бүрэлдэж, төслийн үйл ажиллагаанд оролцоно. НАЧА-ны дарга төслийн даргаар ажиллаж, төслийн хэрэгжилт болон удирдлагыг хариуцах ба тус албаны дэд дарга нь төслийн менежерийн үүргийг гүйцэтгэж, төслийн зохион байгуулалт ба техникийн үйл ажиллагааг хариуцаж ажиллана. ЖАЙКА-ын төслийн мэргэжилтэн нь шаардлагатай техникийн гарын авлагаар хангаж, Х/Т болон Х/Т-АХ-д төслийн үйл ажиллагаа, хэрэгжилттэй холбоотой зөвлөмж, зааварчилгааг өгөх юм. ХЗХ (Хамтарсан Зохицуулах Хороо) нь холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа, хоорондын уялдаа холбоог зохицуулах үүргийг гүйцэтгэнэ.

Тус төсөл нь Дэлхийн банкны “Улаанбаатар хот-Цэвэр агаар төсөл” зэрэг бусад хандивлагч байгууллагатай хамтарч, уялдаа холбоотой ажиллах ба ЖАЙКА-ын холбогдох бусад төсөл, хөтөлбөртэй холбогдон харилцан үр дүнтэй байдлыг бий болгохыг эрмэлзэх болно.



**Схем: Төсөл хэрэгжилтийн бүтэц, тогтолцоо**

### Хүснэгт: ХЗХ (Хамтарсан Зохицуулах Хороо)

<p>Дарга</p> <ol style="list-style-type: none"> <li>1) Нийслэлийн Орлогч дарга</li> </ol> <p>Гшшүүд</p> <ol style="list-style-type: none"> <li>2) Агаарын бохидлыг бууруулах Үндэсний Хороо</li> <li>3) Эдийн Засийн Хөгжлийн Яам</li> <li>4) Уул Уурхайн Яам</li> <li>5) Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам</li> <li>6) Мэргэжлийн Хяналтын Газар</li> <li>7) Цаг уур, Орчны шинжилгээний газар</li> <li>8) Эрчим Хүчний Яам</li> <li>9) Нийслэлийн Стратегийн бодлого, төлөвлөлтийн газар</li> <li>10) ЗАА-ны Инженерийн байгууламжийн хэлтэс</li> </ol> <p>Нарийн бичгийн газар</p> <ol style="list-style-type: none"> <li>11) Нийслэлийн Агаарын Чанарын Алба</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1) ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар</li> <li>2) ЖАЙКА-ийн Токио дахь төв оффис</li> <li>3) ЖАЙКА-ийнн төслийн мэргэжилтэн</li> <li>4) ЖАЙКА-аас томилсон холбогдох хүмүүс</li> </ol>
--	---